



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 14/07

Пионер толгой

**Өмчлөлийн газрын зөрчил  
арилгах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.17, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 13.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 14 дүгээр хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Сумын хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан иргэдийн зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү талбай хашаалсан, зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг арилгаж, нэмж өмчлүүлэх ажлыг зохион байгуулж зөрчлийг арилгасугай.

2. Газар дээрх бодит талбайн хэмжээг мэргэжлийн байгууллагын хэмжилтийг үндэслэн тодорхойлж, бусдын эзэмшил, өмчлөл, ашиглалтын газар, шугам сүлжээний газар, авто замын газруудтай давхцаагүй байх гэх мэт холбогдох хууль журамд заасан шаардлагыг хангасан тохиолдолд газрын кадастрын зургийг үндэслэн бодит талбайн хэмжээг захирамж гарган залруулахыг сумын Засаг дарга (Б.Гантулга)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга (С.Алтанцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА **С. Эрлэ**

**Ч.ЭРДЭНЭ-ОЧИР**



1421095